

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт “Геодези, зураг зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан” гэснийг “Геодези, зураг зүйн тухай хуулийн 26, 27 дугаар зүйлд заасан” гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 12.2 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай заалтууд нэмсүгэй.

1/12.2 дугаар зүйлийн 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг:

“8. байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь албан ёсны баримт бичиг, арга хэмжээнд газар зүйн албан ёсны нэрийг хууль бусаар өөрчлөн хэрэглэсэн, монгол хэлнээс бусад хэлээр орчуулсан, бусад хэлний дуудлагаар галигласан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.гадаадын байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр геодези, зураг зүйн үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд гадаадын иргэнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, гадаадын хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Сургалт, нийтийн хэрэгцээнд зориулсан сэдэвчилсэн газрын зураг, атлас, үндэсний атласыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй хуулбарлан олшруулж борлуулсан, газрын зургийн хэмжээг өөрчлөн масштабгүй болгосон, нутаг дэвсгэрийн хэлбэрийг гажуудуулж хэвлэсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хувилж, хэвлэсэн газрын зураг атласыг хураана.

11.Сургалт, нийтийн хэрэгцээнд зориулсан сэдэвчилсэн газрын зураг, атлас, үндэсний атласын агуулгыг геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй ашигласан, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээнд байршуулсан газрын зурагт нутаг дэвсгэрийн хэлбэрийг гажуудуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Газрын зургийн масштабыг томруулан зохиосон, хэвлэж албан ёсны баримт бичигт ашигласан, газрын зураг, атлас зохиоход нэг маягийн суурь ашиглаагүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.тусгай зөвшөөрөлгүй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн Монгол орны газрын зураг, атлас үйлдсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хувилж хэвлэсэн газрын зураг, атласыг хураана.

14.Геодезийн хэмжих хэрэгсэл эзэмшигчийн бүртгэлийг үндэслэлгүйгээр солих, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын гэрчилгээг хуурамчаар үйлдсэн, нарийвчлал, загварын туршилтад хамрагдаагүй, баталгаажуулалт хийгдээгүй геодезийн хэмжих хэрэгсэл ашигласан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 12.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалт, мөн зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/12.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт:

“1.1.батлагдсан солбицол, өндөр, гравиметрийн тогтолцоо, эринд нийцүүлээгүй, эсхүл хийгээгүй;”

2/12.2 дугаар зүйлийн 3.1 дэх заалт:

3.1.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй, тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг хугацаа хоцорч мэдүүлсэн;”

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11, 11.1, 11.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
3.4.геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

“3.4.геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх”

2 дугаар зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 3.4 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

“3.23.зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх”

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
3.23.зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх	Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

3 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3.д дахь дэд заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

“13.1.3.д.батлан хамгаалах, улсын хил хамгаалах зориулалттай болон энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан тусгай зориулалтын байр зүйн болон дэвсгэр зураг”.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 19.16 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “газар орны нэр” гэсэн нэр томъёог “газар зүйн нэр” гэж, “газар зүйн зурагт” гэснийг “газрын зурагт” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10 дахь заалтын “газар, усны нэр” гэснийг “газар зүйн нэр” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “/газар, усны/” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.1.7.газар зүйн нэр, засаг захиргааны нэгж, гудамж, зам, талбай, хуулийн этгээдийн нэр, хаяг;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.14 дэх заалтыг дор дурдснаар өөрчлөн найруулсугай:

“7.1.14.газар зүйн уламжлалт нэр;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.7 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

28 дугаар зүйлийн 28.1.7 дахь заалт:

“28.1.7.геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгоход 500000, сунгахад 300000 төгрөг, үрэгдүүлсэн тусгай зөвшөөрлийн баримтыг нөхөн олгоход 50000 төгрөг;”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.12 дахь заалт нэмсүгэй:

1/ “7.1.12.Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “цэсийг” гэснийг “цэс, солбицлыг” гэж, 14.2 дахь хэсгийн “заагийг” гэснийг “зааг, солбицлыг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

1/14.4 дэх хэсэг:

“14.4.Хилийн цэс, нутаг дэвсгэрийн заагийн солбицол тодорхойлох, тэмдэгжүүлэх ажлыг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн шатны Засаг даргатай хамтран зохион байгуулна.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хэмжил зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй.

1/8.1.6 дахь заалт:

“8.1.6.геодези, зураг зүйн хэмжилт, зураглал”

2 дугаар зүйл. Хэмжил зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “8.1.1-8.1.4-т” гэснийг “8.1.1-8.1.4, 8.1.6-д” гэж, 10.3 дахь хэсгийн “8.1.1-8.1.4-т” гэснийг “8.1.1-8.1.4, 8.1.6-д” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202... оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1997 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталсан Геодези, зураг зүйн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Геодези, зураг зүйн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг